



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 486

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн охин компаниудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэрийн 73,912,314.00 (далан гурван сая есөн зуун арван хоёр мянга гурван зуун арван дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу салбар компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн
486 дугаар тогтоолын хавсралт

**"БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ОХИН
КОМПАНИУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ
ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Байршил, салбар
1	Мицубиши Эл 200, 30-75 ХОҮ, MMBJNK7404D004535	2003/2013	20,000,000.00	1,500,000.00	"Ховд ЦТС" ХХК
2	УАЗ-220692 фургон, 49-95 ХОА, 374100A0405792	2010/2010	20,000,000.00	800,000.00	"Ховд ЦТС" ХХК
3	Хьюндай грейс, 79-85 ХОҮ, KMJFD37BP2K534614	2002/2002	4,712,314.00	500,000.00	"Ховд ЦТС" ХХК
4	УАЗ220892 Пургон, 59-81 ХОА	2010	18,000,000.00	800,000.00	"Дөргөн" УЦС
5	Хьюндай верна, 49-21 УВХ	2012	11,200,000.00	400,000.00	"Увс ЦТС" ХХК
Нийт дүн			73,912,314.00	4,000,000.00	-
			(далан гурван сая есөн зуун арван хоёр мянга гурван зуун арван дөрвөн)	(дөрвөн сая)	